



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 10 сарын 28 өдөр

Дугаар А/666

Арвайхээр


Хөрөнгө зарцуулах тухай

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 23 дугаар тогтоолоор батлагдсан “Өвөрхангай аймгийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн багш нарын амжилтыг үнэлэх, урамшуулал олгох журам”-ын 3 дугаар зүйлийн 3.8, 4 дүгээр зүйлийн 4.5, 4.6, 5 дугаар зүйлийн 5.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Өвөрхангай аймгийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн багш нарын амжилтыг үнэлэх, урамшуулал олгох журам”-ын шалгуур үзүүлэлтийг хангаж, мөнгөн урамшуулал олгох 29 багшийн нэрсийг хавсралтаар баталсугай.

2. Багш нарт олгох урамшууллын нийт 58.000.000 (тавин найман сая) төгрөгийг Ерөнхий боловсрол, сургуулийн өмнөх боловсролын багцаас олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Нэмэхбаярт)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011101251